



Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТАГТ ТУХАЙЛСАН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ
БАЙХГҮЙГЭЭС ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС
БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ, ҮР
ДҮНГ БҮРЭН ТООЦОХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ХЭА-2024/20-22-ШТА-ГА

“ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2024 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Утас: 7056-2112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 9977-5390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 9211-6768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 8803-2817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Х.Еркегүл

Утас: 9904-0705 Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	5
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	6
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ.....	7
БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН Ч БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛААГҮЙ, ХҮНИЙ НӨӨЦ ТОГТВОРГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	10
1.1. Хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хэдий ч хүүхэд хамгааллын бодлого боловсруулж батлуулаагүй, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.....	10
1.2. Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд тогтворгүй, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй байна.....	13
БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАТЛАГДСАН ТӨСВИЙН 80 ХУВЬ НЬ УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛАГДАЖ БАЙНА. 16	16
2.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах орон нутгаас санхүүжүүлэх төсвийг төлөвлөж батлуулаагүй байна.....	16
2.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг батлагдсан зориулалт, арга хэмжээгээр нь зарцуулахгүй байна.	18
БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БАЙХГҮЙ ТУЛ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.....	19
3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын аргачлал батлагдсан боловч үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна.....	19
3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлээгүй байна.....	23
3.3. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнтэй хийгдэж байгааг бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.....	26
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:.....	28
ДҮГНЭЛТ: 29	
ЗӨВЛӨМЖ:	30



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Товчлол	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ОУБ	Олон улсын байгууллага
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ЗХГА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгтийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Тулгамдаж буй асуудал	11
Хүснэгт 2	Хүүхэд хамгааллын бүлэгт хамаарах асуудал	12
Хүснэгт 3	Хэрэгжүүлэх арга хэмжээ.	12
Хүснэгт 4	Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа	13
Хүснэгт 5	Нийгмийн бодлогын мэргэжилтний судалгаа.	15
Хүснэгт 6	Хүүхэд хамгааллын үйлчилгээний батлагдсан төсөв	17
Хүснэгт 7	Баталсан болон тооцоолсон төсвийн хуваарилалт.	17
Хүснэгт 8	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын гүйцэтгэл	18
Хүснэгт 9	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийн гүйцэтгэл	18
Хүснэгт 10	Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулах чиглэлээр батлагдсан 2 журам, 6 аргачлал	19
Хүснэгт 11	ХГБХХГ-ын хяналтын үнэлгээ	21
Хүснэгт 12	Үүнээс аймгийн Хүүхэд гэр бүлийн, хөгжил хамгааллын газрын төлөвлөгөөнд туссан байдал	22



ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Графикийн дугаар	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Улсын төсөвт хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах төсөө	9
График 2	Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байдал. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ.	16
График 3	Хэнтий аймгийн хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс, 2020-2022	20
График 4	Хүүхдэд ээлтэй байдлын бүлгийн индекс, 2020-2022	21
График 5	Хүүхэд хамгааллын бодлого баталсан байгууллагын тоо	23
График 6	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд	24
График 7	Боловсролын салбар	24
График 8	Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлага	26
График 9	Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн тоо	26



ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралтын дугаар	Тайлбар
Хавсралт 1	Аудитын илрүүлэлтийн матриц
Хавсралт 2	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн бүртгэл



АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн хийлээ.

Аудитын зорилго:

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог аймгийн ЗДТГ, аймгийн ХГБХХГ, Боловсролын газар, ЭМГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар болон сумдын Засаг даргын үйл ажиллагааны 2019-2023 оны баримт, мэдээллийг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан салбарын албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглалаа. Үүнд:

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц;
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;



- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл;
- НҮБ болон Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмж



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хүүхэд хамгааллын тухай хууль нь анх 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 1-ээс эхлэн дагаж мөрдөхөөр тусгажээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Харин “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ” гэж тус заасан байна.


Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.

Хэнтий аймгийн хэмжээнд хүүхдийн тусламжийн 108 утсанд 2019-2023 онд нийт 421 дуудлага хүлээж авсныг 100% шийдвэрлэсэн байна. Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт 2023 онд 91.5 хувьтай байгаа нь 2022 онтой харьцуулахад 1.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


2019-2023 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 3355 хүүхэд, Хууль зүйн хорооноос үйлчилгээ авсан 172 хүүхэд, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 249 хүүхэд байна.

Хэнтий аймгийн ХГБХХГ нь хүүхэд хамгааллын бодлого, төсвийн санхүүжилт, зарцуулалт, хяналтыг хэрэгжүүлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв нэмэгдэж, 2023 оны байдлаар хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулах санхүүжилт улсын төсвөөс 261.4 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 108.0 сая төгрөгт хүрсэн байна.

Зураг 1. Улсын төсөвт хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах төсөв



Эх сурвалж: ХГБХХГ, Хүүхдийн эрхийн талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн хураангуй тайлан, 2023



Эх сурвалж: аймгийн ХГБХХГ,



БҮЛЭГ 1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО БҮРДСЭН Ч БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ БАТЛУУЛААГҮЙ, ХҮНИЙ НӨӨЦ ТОГТВОРГҮЙ, ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

1.1. Хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хэдий ч хүүхэд хамгааллын бодлого боловсруулж батлуулаагүй, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д хүүхэд хамгааллын талаар мөрдөж байгаа хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах чиглэлээр 1 арга хэмжээг, мөн аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Хэнтий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд хүүхдийн аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, хүүхэд хамгааллыг сайжруулах чиглэлээр 3 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд боловсролын салбарт 1 зорилт, 1 арга хэмжээ, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт 1 зорилт, 1 арга хэмжээ, амар тайван, орон нутгийн хамгаалалтын чиглэлээр 1 зорилт, 1 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ.

Эдгээр бодлогын баримт бичигт хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээ нь 2016 онд батлан хэрэгжүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүүхэд хамгааллын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх чиглэл болон хүүхэд хамгааллын чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулах төрийн байгууллагын нийт 58 чиг үүрэг байгаагаас 6 чиг үүрэгтэй нь уялдаж байна.

Энэ нь дунд хугацааны бодлогын баримт бичигт Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээг бүрэн төлөвлөөгүй байгааг харуулж байна.

Мөн Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын стратеги төлөвлөгөөг авч үзвэл Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн 27 чиг үүргээс 12 чиг үүрэгтэй уялдуулан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Соёл, урлагийн газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөнд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээг тусгаагүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн аливаа хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах хариу үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн орон нутгийн оролцогч талуудын 58 чиг үүргийг тусгасан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх чиглэл бүхий төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод 27 чиг үүргийн хэрэгжилтийг хангахаар арга хэмжээг төлөвлөсөн байна. Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөнд тусгаагүй 31 чиг үүргийг дээрх бодлогын баримт бичиг, албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусган хэрэгжилтийг нэг мөр ханган ажиллах шаардлагатай байна.

Эдгээр нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5, 6, 7, 8, 9, 9¹ дүгээр зүйл болох гэр бүл, нийгмийн бүхий л орчинд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хамгаалах, зайлшгүй дунд хугацааны бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ байна.



Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1-т “нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;”, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т “тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;”, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын даргын 2022 оны А/72 дугаар тушаалаар “Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрэм”-ийн 3.3.1-т “Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх хууль тогтоомж эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, сурталчлах бөгөөд тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах;” гэсэн заалтын хүрээнд аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулж батлуулаагүй байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас 2021 онд хүүхэд хамгааллын нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлыг өмнөх жилүүдийн судалгаа, статистик мэдээнд үндэслэн тодорхойлсон байна.

Хүснэгт 1.

д/д	Тулгамдаж байгаа асуудал
1	Өсвөр насныхны архи тамхины хэрэглээ, эрсдэлт зан үйлийн талаарх тодорхой судалгаа байхгүй
2	Хүүхэд хохирч буй бэлгийн хүчирхийллийн гэмт хэргүүд 2-3 холбогдогчтой, урт хугацаанд үйлдэгдсэн
3	Хүүхдээ асран хамгаалахгүй, үүргээ биелүүлэхгүй байгаа эцэг эхийн тоо нэмэгдэж байгаа
4	13-17 насны бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийн улмаас жирэмсэлсэн, үр хөндүүлсэн хохирогчдын тоо нэмэгдсэн
5	Өсвөр насныхны зан үйл, бэлгийн харилцаанд орох тохиолдол нэмэгдсэн
6	Хүүхэд хүчирхийлэлд өртөж байгаа тохиолдлын дийлэнх нь гэр бүлийн орчинд байна
7	Нийгмийг цочроосон тохиолдол жил бүр гарах болсон
8	Хүүхдэд орчны аюулгүй байдалтай холбоотой үүсэх эрсдэлүүд байсаар байна /тогонд цохиулах, нүхэнд унах, нохойд хазуулах/

Тулгамдаж байгаа асуудалд үндэслэн цаашид хүүхдийн хөгжлийг дэмжих, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж, хүүхдэд ээлтэй аймаг болох арга хэмжээг салбар дундын хамтын ажиллагааг хангасан, аймгийн хэмжээний бодлого төлөвлөлттэйгөөр зохион байгуулах шаардлага үүссэн тухай хэлэлцэн Аймгийн ИТХ-ын 2022 оны 02 дугаар тогтоолоор 2022 оныг “Хүүхэд хөгжил хамгааллын жил” болгон зарласан.

Зорилтот жилийн хүрээнд хүүхдийн хөгжил, оролцоо, хүүхдийн аюулгүй байдал, хамгаалал гэсэн 2 зорилтын 28 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тайланг аймгийн ИТХ-ын 2022 оны 16 дугаар хуралдаанд танилцуулан “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж 2023 онд энэхүү зорилтот жилийн арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулж өсвөр насныханд, бага насныханд, хүүхдийн аюулгүй байдал, хамгаалал гэсэн 3 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, тайланг аймгийн ИТХ-ын 22 дугаар хуралдаанд танилцуулжээ.



“Хүүхэд хөгжил, хамгааллын жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлэх зорилгоор “Хүүхэд эрдэнэ хөгжлийн төв” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан орон нутгийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх 2020-2022 онуудын мэдээлэл, судалгаанд үндэслэн хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индексийг тооцуулсан байна. Индексийг хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн боловсрол, хүүхдийн аюулгүй байдал, хүүхэд хамгаалал, хүүхдийн оролцоо гэсэн 5 бүлгийн 25 шалгуур үзүүлэлтээр үзэхэд хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс 5.89 байна, энэ нь өмнөх оноос 0.47, 2020 оноос 0.14-өөр өссөн гэж дүгнэжээ. Дүгнэлтэд дурдсанаар хүүхэд хамгаалал бүлгийн индекс 5.95 байгаа нь дундаж түвшинд байгаа гэж үзсэн байна.

Судалгааны дүнд нийт 25 үзүүлэлтээс 9 үзүүлэлтийн индекс дунджаас доогуур байгаа тул эдгээр асуудалд анхаарал хандуулж цаг алдалгүй арга хэмжээ авах шаардлагатай байгааг онцолсноос хүүхэд хамгааллын бүлэгт хамаарах 4 асуудал байна.

Хүснэгт 2. Хүүхэд хамгааллын бүлэгт хамаарах асуудал

д/д	Үзүүлэлт/Асуудлууд	Индекс	Бүлэг
1.	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын тоо	2.69, 4.38, 3.7	Хүүхэд хамгаалал
2.	Гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тоо	4.51, 5.68, 4.22	Аюулгүй байдал
3.	Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо	3.4, 4.87, 5.19	Аюулгүй байдал
4.	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо	5.31, 1.35, 5.17	Хүүхэд хамгаалал

Дээрх төрийн бус байгууллагаас хийсэн судалгааны дүгнэлтэд үндэслэн хүүхдэд ээлтэй байдлыг сайжруулах 5 зорилгын 64 үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмжийг өгсөн байна. Зөвлөмжид “Хүүхэд бүрийг аливаа дарамт, хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрахаас урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээг орчин үеийн шаардлагад нийцүүлэх зорилго”-ын хүрээнд 11 үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөжээ.

Хүснэгт 3. Хэрэгжүүлэх арга хэмжээ.

д/д	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1	Ард иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс аливаа хүчирхийлэл, архидалт, мансуурал, хүн худалдаалахаас урьдчилан сэргийлсэн, яаралтай хамгаалж, таслан зогсоох бодлого, стратегийг батлан хэрэгжүүлэх;
2	Хүүхэд хөдөлмөр эрхлэх, гудамжинд хоноглох, хараа хяналтгүй явах, архи, тамхи, мансуурах бодис хэрэглэх, худалдаалах, гэмт хэрэгт өртөх, хүүхэд хүчирхийлэх, худалдаалах, охид эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт өртөхийг сэрэмжилсэн, хориглосон дүрэм журмыг орон нутгийн хэмжээнд батлан мөрдүүлэх;
3	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд эерэг аргаар хүмүүжүүлэх аргыг нэвтрүүлэх, олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг бүх насны хүний онцлогт тохирсон хэлбэрээр өрнүүлэх;
4	Бүх шатны төрийн, төрийн бус, соёл, шашны байгууллагууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр сурталчилгаа нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;
5	Хүүхэд хамгааллын хариу арга хэмжээний хүрээнд хамтарсан багийн гишүүдийн кейс илрүүлэх, бүртгэх, кейс менежментийн үйлчилгээг үзүүлэх чадавхыг бэхжүүлэх, мэргэжил, арга зүйгээр хангах, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхийн сацуу шаардлагатай гарын авлага, арга зүйн зааварчилгааг боловсруулан гаргах;
6	Хохирогч хүүхдийг нөхөн сэргээх ажиллагааны хүрээнд эерэг аргаар хүмүүжүүлэх арга, урлагийн сэтгэл засал, нийгэмшүүлэх ажлаар дамжуулан хүүхдийг нөхөн сэргээх, хөгжлийг дэмжих зэрэг дэвшилтэт нөхөн сэргээх арга зүйг нэвтрүүлэх;
7	Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд ирсэн ихэнх дуудлага нь мэдээлэл, зөвлөгөө хүссэн дуудлага байдаг мөн өсвөр үе залуучууд, ялангуяа охидод зөвлөгөө өгөх үйлчилгээ дутагдалтай байгаа тул хүүхдийн эрх, эрүүл мэнд, хамгааллын асуудлаар зөвлөгөө мэдээлэл өгөх цахим платформыг бий болгох;
8	Олон улсад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, зохих арга хэмжээ авах талаар нэгдсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны материалыг агуулсан цахим платформ хуудсыг нийгмийн ажилтан, эмч, багш зэрэг салбарын мэргэжилтнүүдэд



	төдийгүй бусад мэргэжлийн бус хүмүүсийг сургах, цаг үеийн мэдээллээр хангах зорилгоор ашигладаг сайн туршлагыг турших, хэрэгжүүлэх;
9	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх хууль, тогтоомжийг боловсруулж, хэрэгжүүлэх;
10	Гэр бүлд үзүүлэх чухал үйлчилгээ болох гэр бүлд зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг дэмжих механизмыг бий болгох;
11	Бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээ, хүүхэд асрах үйлчилгээ, хүүхдийн авьяасыг хөгжүүлэх, өдөр өнжүүлэх үйлчилгээний стандартуудыг шинээр батлан гаргах;

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөнд зөвлөмжөөр өгсөн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байгаа гэх боловч цаашид зөвлөмжид туссан арга хэмжээг хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт тусгах, салбар байгууллагын үйл ажиллагааны уялдааг ханган хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

1.2. Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд тогтворгүй, хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18-21 дүгээр зүйлд Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлж өгсөн байна. Мөн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын даргын 2022 оны А/72 дугаар тушаалаар “Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрэм”-д, хүүхдийн хөгжил, хамгааллыг чиглэсэн 11 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 4. Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа

3.3	Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа
3.3.1	Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаар хууль тогтоомжийн эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, сурталчлах бөгөөд тухайн нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах
3.3.2	Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг чадавхжуулах, хүүхдийг оролцооны аргад суралцуулах, идэвхжүүлэх, урамшуулах замаар хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих сургалт, мэдээлэл, нөлөөллийн хамтын ажиллагааг өргөжүүлэх
3.3.3	Эрх нь зөрчигдсөн хүүхдийг төрийн үйлчилгээгээр хангаж, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн халамж, асрамжийн зэрэг үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах
3.3.4	“Хүүхдийн төлөө зөвлөл, “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”, “Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги”-ийн гишүүд, хүүхдийн элчийг мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах, хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх
3.3.5	“Насан хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг эцэг эх, олон нийтэд сурталчлан таниулах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаарт нийцүүлэн тэднийг хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлөөр хангахад чиглэгдсэн зэрэг ажлыг зохион байгуулах
3.3.6	Хүүхдийн хүмүүжил, төлөвшилийг сайжруулах чиглэлээр өөрсдийнх нь оролцоонд тулгуурласан аргачлалыг хэрэгжүүлж, тэдний өөрийн үнэлэмжийг дээшлүүлэхэд онцгой анхаарч, амьдрах ухаан, Монгол ахуй, уламжлал, ёс заншлыг түгээн дэлгэрүүлэхэд эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгч, олон нийтийн оролцоог ханга ажиллах
3.3.7	Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх чиглэлийн дугуйланг дэмжих, тухайн хичээлийн жилийн үргэлжлэх хугацааны зорилтын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудтай үр дүнтэй хамтран ажиллах
3.3.8	Хүүхдийн асуудлаар тухайн нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж буй байгууллага, хуулийн этгээд, иргэний үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих, арга зүйн дэмжлэг үзүүлэх
3.3.9	Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ажилладаг байгууллага, зуслан, ордон, төвүүдийн судалгаа, мэдээллийг нэгтгэх замаар мэдээллийн сан бий болгон дүгнэлт хийж, олон нийтэд сурталчлах, хамтран ажиллах
3.3.10	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах, тэдгээрийн хөгжил, төлөвшил, хамгааллыг сайжруулах, нийгэмшихүйн чиглэлээр гаргасан санал, санаачилгуудыг дэмжих, хамтран ажиллах
3.3.11	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан хуулийн этгээд, хувь хүн, хүүхдийг алдаршуулах, шагнаж урамшуулах



Албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-ыг Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуультай уялдуулан Гэр бүл хүүхэд, залуучуудын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/42 дугаар тушаалаар баталсан байна.

Энэ албан тушаалын тодорхойлолт нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй хэрхэн уялдаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд батлагдсан албан тушаалын тодорхойлолтод тусгаагүй хуулиар хүлээсэн 15 чиг үүрэг байна. Албан тушаалын тодорхойлолтод тусгаагүй хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг нь авч үзвэл тодорхой хэмжээнд хэрэгжсэн 5, хэрэгжилт тодорхой бус 5, орон нутгийн хэмжээнд огт хэрэгжүүлээгүй 5 чиг үүргүүд байна.

Хэрэгжилт тодорхой бус, огт хэрэгжилт байхгүй хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг албан хаагчдын “Албан тушаалын тодорхойлолт”-д оруулж шинэчлэх шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт 4 төрлийн мэдээллийн санд хүчирхийлэлтэй холбоотой дуудлага мэдээлэл бүртгэх, уралдаанч хүүхдийн, эрсдэлт бүлгийн, хүүхэд харах үйлчилгээний бүртгэл хөтлөх, хохирогчид үзүүлсэн үйлчилгээ, хохирогчийн мэдээлэл, хамтарсан багуудаас кейст үзүүлсэн үйлчилгээ, төлөвлөгөө зэрэг мэдээллийг бүртгэн ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн утас /ХТУ-108/ программд харьяаллын дагуу Хэнтий аймагт шилжүүлсэн хүчирхийлэлтэй холбоотой дуудлага мэдээллийн бүртгэлийг оруулдаг бөгөөд 2019-2023 онд нийт 421 зөрчлийн дуудлага мэдээллийг бүртгэн холбогдох байгууллагад шилжүүлэн ажилласан байна.

E-Tuslamj.mn программыг 2022 оноос ашиглалтад оруулж 14 хохирогчид үзүүлсэн үйлчилгээ, хохирогчийн мэдээллийн бүртгэлийг хөтлөн ажилласан. 2023 оноос энэхүү программын хөгжүүлэлт хийгдэж байгаа учир ашиглахгүй байна. Энэхүү программд Түр хамгаалах байрны Нийгмийн ажилтан мэдээллийг өөрийн эрхээр нэвтэрч оруулдаг байна.

Мөн уралдаанч хүүхэд, эрсдэлт хүүхэд, хүүхэд харах үйлчилгээг Эйбл системд 2018 оноос эхлэн бүртгэн ажиллаж байна. 2019-2023 оны хугацаанд 676 эрсдэлт бүлгийн хүүхэд, 2339 уралдаанч хүүхдийн бүртгэл, 15 хүүхэд харах үйлчилгээний бүртгэлийг хийн ажиллаж байна.

Хамтарсан багаас кейст үзүүлсэн үйлчилгээний төлөвлөгөө, үйлчилгээний талаар холбогдох мэдээллийг “НАМС” программд /nas.fcy.gov.mn/ 2022 оны 10 сараас эхлэн бүртгэн ажиллаж байсан. Энэхүү программ одоогоор ашиглахгүй байна.

Хүүхдийн тусламжийн 108 утас болон НАМС программ хангамжид хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл, хамтарсан багуудаас кейст үзүүлсэн үйлчилгээ, төлөвлөгөө зэрэг ижил төрлийн мэдээллийг 2 программд оруулж байгаагаас сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд ажлын ачааллыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлдэг байна.

Эдгээр мэдээллийн санд сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд, хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын асуудал хариуцсан мэргэжилтэн тус бүр өөрийн эрхээр хандаж мэдээллийг оруулан ажилладаг бөгөөд нэгдсэн үндсэн мэдээллийг аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нэгтгэдэг байна.

Мөн шаардлагатай мэдээллийн сангийн программ хангамж ажиллахгүй байгаа учир Хүүхэд хамгааллын судалгааг файл хэлбэрээр авч нэгтгэн мэдээллийн санг үүсгэн ажиллаж байна.

Дээрх мэдээллийн сангуудыг нэгтгэн “Хүүхдийн хөгжил, хамгаалал”-ын нэгдсэн санг үүсгэж хүчирхийлэлтэй холбоотой дуудлага мэдээлэл, уралдаанч хүүхдийн, эрсдэлт бүлгийн, хүүхэд харах үйлчилгээний бүртгэл, хохирогчид үзүүлсэн үйлчилгээ, хохирогчийн мэдээлэл, хамтарсан багуудаас кейст үзүүлсэн үйлчилгээ, төлөвлөгөөний талаарх мэдээллийг нэг сангаас авах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна.



Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар байгууллагын орон тоог баталсан байна. Орон тоонд Хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн 1, Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн 1 байхаар баталсан байна. Үүнээс хойш 2021 онд бүтэц орон тоог шинэчлэн баталсан хэдий ч хүүхэд хамгааллын чиглэлийн орон тоонд өөрчлөлт ороогүй байна.

Харин Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан бүтэц, орон тоонд Хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн 1, Хүүхдийн эрхийн улсын байцаагч 1, Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн 1, Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн 1 ажиллахаар байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн ажлын сул орон тооны захиалгыг 2022 онд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд өгч ажилласан бөгөөд энэ албан тушаалд төрийн албаны ерөнхий шалгалт өгч тэнцсэн иргэн байхгүй байна. Одоогоор Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн албан тушаалыг газрын дарга хавсран гүйцэтгэж байна.

Хүснэгт 5. Нийгмийн бодлогын мэргэжилтний судалгаа.

Сумын нэр	Ажиллаж байгаа байдал	Мэргэжил	Төрд ажилласан жил	Нийгмийн бодлогын мэргэжилтнээр ажилласан жил
Батноров	үндсэн	Олон улс судлал, Хятад хэл	8 жил	2 жил
Батширээт	үндсэн	Аялал жуулчлал-зочид буудлын менежер, төрийн удирдлага-хүний нөөц	11 жил	1 жил
Баян-адарга	үндсэн	Биологийн багш	-	1 сар
Баянмөнх	Үндсэн	Холбооны инженер	4 жил	2 жил
Баян-овоо	үндсэн	Хөдөлгөөн засалч	8 жил	7 жил
Баянхутаг	үндсэн	эрх зүйч	12 жил	12 жил
Биндэр	үндсэн	Хэвлэл эх бэлтгэл, дизайн	4 жил	4 жил
Бор-Өндөр	үндсэн	боловсрол судлаач	4 жил	4 жил
Галшар	үндсэн	Спортын сэтгүүлч	2 жил	1 жил
Дадал	Үндсэн	Менежмент төрийн захиргаа удирдлага	9 жил	8 жил
Дархан	үндсэн	Төрийн захиргаа удирдлага	10 жил	10 жил
Дэлгэрхаан	үндсэн	Монгол хэлний багш	16 жил	1 жил
Жаргалтхаан	үндсэн	эрхзүйч	12 жил	8 жил
Мөрөн	Ажил хавсардаг	Нягтлан бодогч	10 жил	7 жил
Норовлин	үндсэн	Олон улсын эрх зүйч	6 жил	4 жил
Өмнөдэлгэр	үндсэн	эрхзүйч	18 жил	16 жил
Хэрлэн сум	үндсэн	Төрийн захиргаа удирдлага	2.9 жил	2 жил
Цэнхэрмандал	Гэрээт	Менежмент мэдээллийн систем	6 жил	1 сар

Сумдад 18 нийгмийн бодлогын түшмэл ажиллаж байгаагаас ажил хавсран болон гэрээтээр ажиллаж байгаа 2 албан хаагч байна. Ажилласан жилийн хувьд аудитын хамрах хүрээгээр авч үзвэл 1-4 жил ажиллаж байгаа 11 албан хаагч буюу нийт албан хаагчдын 61.1 хувийг эзэлж байгаа нь хүний нөөц тогтворгүй байгааг харуулж байна.

Мөн 9 албан хаагч буюу нийт албан хаагчдын 50 хувь нь БШУС-ын 2022 оны А/160 дугаар тушаалаар баталсан Мэргэжлийн чиглэл индексээр албан тушаалын тодорхойлолтын мэргэжлийн чиглэлтэй таарахгүй байна. Нийгмийн бодлогын



мэргэжилтний албан тушаалаар 4 нь 10-аас дээш жил, 2 нь 5-аас дээш жил, 3 нь 5 жил хүртэл хугацаанд ажилласан албан хаагчид байна.

Үүнээс үзэхэд сумдад ажиллаж байгаа Нийгмийн бодлогын мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлогыг хэрэгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад шат дараатай хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

График 2. Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байдал. Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ.



Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хувьд байгууллагын сургалтын төлөвлөгөөг жил бүр батлуулж, төлөвлөгөөний дагуу сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд чадавхжуулах сургалтыг 2019-2023 оны хугацаанд 19 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 150 албан хаагчийг хамруулжээ.

Мөн хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээгээр дамжуулан 5 жилийн хугацаанд давхардсан тоогоор 40 албан хаагчийг арга зүйгээр ханган ажилласан байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, багт хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулах, сум, багийн Засаг дарга нь нийгмийн ажилтны ажиллах нөхцөл боломжоор хангах үүргийг хариуцах талаар 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан хэдий ч тухайн орон тоонд шаардагдах төсөв зардал шийдэгдээгүй учир энэ заалт хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 2. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАТЛАГДСАН ТӨСВИЙН 80 ХУВЬ НЬ УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛД ЗАРЦУУЛАГДАЖ БАЙНА.

2.1. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах орон нутгаас санхүүжүүлэх төсвийг төлөвлөж батлуулаагүй байна.

Аймгийн ХГБХХГ-ын 2019 оны төсийн төсөлд хүүхэд хамгааллын хууль, Хүний хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, Хүүхдэд ээлтэй засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээг 71.7 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлсэн байна. 2022 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын зардлыг 50.0 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн боловч хэрэгжүүлэх арга хэмжээ, суурь түвшин, хүрэх үр дүн нь тодорхойгүй байна. Харин 2023 оны төсвийн төсөлд хүүхэд хамгааллын зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхой тусган 130.8 сая төгрөгийг төсөвлөж хүргүүлжээ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5, “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын 5.2, “Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх, санхүүжүүлэх журам”-ын 6.2, “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”-ын 9.2-д дэх заалтуудад тухайн шатны Засаг дарга нэг цэгийн үйлчилгээний



төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг төсвийн төсөлд тусгаж, ИТХ-аар батлуулах талаар заасан боловч хэрэгжээгүй байна.

Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байрны харуул хамгаалалтын зардлыг шийдвэрлэхээр тусгаж аймгийн ЗД-ын нөөц сангаас 2019 онд 6.0 сая төгрөг, 2020 онд 18,000.0 мянган төгрөг, 2021 онд 25,000.0 мянган төгрөг, 2022 онд 15,000.0 мянган төгрөг, 2023 онд 20,000.0 мянган төгрөгийн санхүүжилт баталж, олгосон байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд 2019 онд 3,793.0 мянган төгрөг, 2020 онд 1,907.9 мянган төгрөг, 2021 онд 20,543.5 мянган төгрөг баталсан бол 2022 оноос эхлэн зардлын хөтөлбөр, зориулалт арга хэмжээгээр нь ангилж урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах нөхөн сэргээх хариу үйлчилгээний зардал гэж тус тусад нь баталсан байна. Үүнд:

Хүснэгт 6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний батлагдсан төсөв /Мянган төгрөг /

Зардлын зориулалт	Арга хэмжээний нэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
80233	Хүүхэд хамгаалал	3,793.0	1,907.9	20,543.5	-	
80236	Эрсдлийн болон НБҮ хийх				2,581.3	1,806.9
80237	Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал				68,162.7	199,467.6
80238	УСАХ-ний зардал				77,857.5	60,140.2
	Нийт дүн	3,793.0	1,907.9	20,543.5	148,601.5	261,414.7

Дээрх хүснэгтээс үзвэл хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг 2022, 2023 онуудад шаардлагатай нөөцийг тодорхойлж зардлыг зориулалт, арга хэмжээгээр нь хуваарилж баталсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, 27 тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг үндэслэн хүүхэд хамгааллын үйлчилгээний төсвийг хуваарилан олгож байна.

Хэнтий аймгийн хувьд дээрх нормативыг үндэслэн шуурхай тусламж үйлчилгээ, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг өмнөх оны тоо мэдээллийг ашиглан тооцоолж үзлээ. Үүнд:

Хүснэгт 7. Баталсан болон тооцоолсон төсвийн хуваарилалт. /Мянган төгрөг/

Үзүүлэлт	Шуурхай тусламж үйлчилгээ			Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ			Урьдчилан сэргийлэх үйлчилгээ		
	Тооцоолсо н	Баталса н	Зөрүү	Тооцоолсо н	Баталса н	Зөрүү	Тооцоолсо н	Баталса н	Зөрүү
2022 он	11,049.0	2,581.3	-8,467.7	70,684.0	68,162.7	-2,521.3	63,970.1	77,857.5	13,887.4
2023 он	12,876.0	1,806.0	-	151,802.0	199,467.6	47,665.6	64,438.1	60,140.2	-4,297.9
			11,070.0			6			

Дээрх хүснэгтээс харахад шуурхай тусламж үйлчилгээний зардлыг бага хуваарилсан үзүүлэлттэй байгаа бол хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг оновчтой хуваарилан төсөвлөсөн байна.



2.2. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг батлагдсан зориулалт, арга хэмжээгээр нь зарцуулахгүй байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардалд 2019 онд 3,742.8 мянган төгрөг, 2020 онд 1,748.0 мянган төгрөг, 2021 онд 20,540.1 мянган төгрөг, 2022 онд 147,826.2 мянган төгрөг, 2023 онд 261,280.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнийг зориулалт, арга хэмжээгээр нь авч үзвэл:

Хүснэгт 8. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Зардлын төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Хүүхэд хамгаалал	3,742.8	1,748.0	20,540.1		
Хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардал				68,161.8	199,342.3
Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд				1,806.9	1,798.4
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал				77,857.5	60,140.2
ДҮН	3,742.8	1,748.0	20,540.1	147,826.2	261,280.8

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж байгаа ч батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу зарцуулагдаагүй байна. Тухайлбал 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар:

- Хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардалд 2022 онд 16,631.7 мянган төгрөг, 2023 онд 51,236.1 мянган төгрөгийг;
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2022 онд 129,387.6 мянган төгрөг, 2023 онд 208,246.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 9. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын төсвийн гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Зардлын төрөл	2022 он			2023 он		
	Төсвийн гүйцэтгэл	Аудитаар	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл	Аудитаар	Зөрүү
Хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардал	68,161.8	16,631.7	- 51,530.1	199,342.3	51,236.1	- 148,106.2
Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд	1,806.9	1,806.9	0.0	1,798.4	1,798.4	0.0
Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал	77,857.5	129,387.6	51,530.1	60,140.2	208,246.4	148,106.2
ДҮН	147,826.2	147,826.2	0.0	261,280.8	261,280.8	0.0

Үүнээс үзэхэд хүүхэд хамгаалах үйлчилгээний нийт зардлын 2022 онд 87.5 хувийг, 2023 онд 79.7 хувийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд тус тус зарцуулсан байна.

Хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардлаас 2022 онд 51,530.1 мянган төгрөгийг, 2023 онд 148,106.2 мянган төгрөгийг урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд шилжүүлэн зарцуулж батлагдсан төсөвт зардлын зориулалт, арга хэмжээг баримтлан ажиллаагүй байна.

Аймгийн ХГБХХГ нь байгууллагын батлагдсан төсөв, төсвийн зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд байршуулдаг. Харин хүүхэд хамгааллын талаар зохион байгуулсан арга хэмжээ, хийсэн ажлыг иргэд олон нийт, орон нутгийн байгууллагуудад танилцуулга бэлдэж тайлагнадаг боловч, тухайн арга хэмжээг зохион байгуулахад зарцуулсан төсвийн зарцуулалтыг хамтад нь тайлагнаж байх шаардлагатай байна.

Дэлхийн зөн ОУБ-аас 2019 онд 5,585.2 мянган төгрөгийн суурин компьютер 4 ш, Нэгдсэн үндэсний байгууллагын Хүн амын сангаас аймгийн ЗДТГ-аар дамжуулан 44,571.8



мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирснийг үндсэн хөрөнгөөр бүртгэсэн боловч Олон улсын донор байгууллагаас шилжиж ирсэн хөрөнгийн зарцуулалтад тавьсан хяналтын тайлан байхгүй байна.

Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээнд 2021 онд 4, 2022 онд 9, 2023 онд 6 хүүхэд үйлчлүүлсэн байна. Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийж, тухайн үйлчлүүлэгчид тохирсон цогц үйлчилгээ үзүүлэх кейс төлөвлөгөөг боловсруулж байгууллагын удирдлагаар батлуулан ажилладаг байна. Үүнээс түүвэрлэн 4 кейсийг сонгон цогц үйлчилгээг бүрэн авч байгаа эсэхийг шалгахад 230122060206 дугаартай кейс төлөвлөгөөнд 8 төрлийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн боловч кейс хаах маягыг дутуу хөтөлж 4 төрлийн үйлчилгээнд хамруулснаар тайлагнасан, 23015922072110 дугаартай кейс төлөвлөгөөнд 6 төрлийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн боловч 4 төрлийн үйлчилгээг үзүүлж 2 төрлийн үйлчилгээг үйлчлүүлэгчийн хүсэлтээр зогсоосон байна. Кейс төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулаагүй, үйлчлүүлэгчид танилцуулж гарын үсгээр баталгаажуулаагүй, кейс хаах маягыг бүрэн хөтлөөгүй зөрчлийг арилгаж, анхан шатны баримтын бүрдэлд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аймгийн ГБХЗХГ-ын даргын 2023 оны А/105 тушаалаар “нууц хадгалах, хамгаалах, боловсруулах журам”-ыг баталж хувь хүний нууцтай танилцах ажилтнуудтай нууцын гэрээг байгуулж ажилласан байна. Хүүхдийн хувийн хэргийг төмөр сейф-д, хаагдсан хувийн хэргийг үдэж байгууллагын архив дотор тусгай цоожтой тавиурт хадгалдаг байна. Төсөв санхүүгийн баримтад кейс төлөвлөгөөг үндэслэн хүүхдийн хувийн хэргийн дугаараар илтгэх хуудас бичиж, зураг, тэмдэглэлд стикер нааж хувь хүний нууцыг хамгаалан ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын албаны автомашиныг 108 гэсэн таних тэмдэг наасан нь хамгаалалтын үйлчилгээ авч буй хүүхдийг сургууль, эрүүл мэндийн байгууллагад хүргэж өгөх, хүүхэд хамгааллын дуудлагаар явахад иргэд олон нийтэд мэдэгдэх, хувь хүний нууц алдагдах нөхцөл бүрдсэн байгааг анхаарах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БАЙХГҮЙ ТУЛ ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналтын аргачлал батлагдсан боловч үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байна.

Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулах чиглэлээр батлагдсан 2 журам, 6 аргачлал байна.

Хүснэгт 10

№	Баталсан албан тушаалтан	Журам, аргачлалын нэр	Батлагдсан он	Дугаар
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал	Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам	2017	А/120, А/178
2		Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээний маягт		
3		Хүүхэд хамгааллын үйлчилгээний багц маягт		
4	Хууль зүй дотоод хэргийн сайдын тушаал	Аюулгүй зэргийн үнэлгээ хийх журам	2020	А/83
5	ЗГХА-ГБХЗХГ-ын даргын тушаал	Хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал	2018	А/236



6	Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журмын хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал,	2019	A/292
7	Хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн элч, Хүүхдийн эрхийн ажилтны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал	2020	A/240
8	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал	2020	A/243
9	Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал	2022	A/216
10	Түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх аргачлал		A/217

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2020 оны А/83 тушаалаар батлагдсан Аюулгүй зэргийн үнэлгээ хийх журмын хүрээнд Аюулгүйн зэргийн үнэлгээ хийх, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан нөхцөл байдлын үнэлгээг хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхдээ ашиглаж байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.9-д “Хүүхдэд ээлтэй орон нутгийн 6 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хүүхдийн хөгжлийг дэмжиж, эрсдэлд нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж Хүүхдэд ээлтэй орон нутаг болно” гэх зорилтыг 2021-2024 онд хэрэгжүүлж хүүхдэд ээлтэй байдлын индексийг жилд 1 нэгжээр ахиулсан байхаар төлөвлөжээ. Энэхүү зорилтын хүрээнд 2023 онд Хэнтий аймгийн хүүхдэд ээлтэй байдлын индексийг тодорхойлуулах судалгааны ажлыг “Хүүхэд эрдэнэ хөгжлийн төв” төрийн бус байгууллагаар хийлгэсэн сайн жишээ байна.

График 3. Хэнтий аймгийн хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс, 2020-2022







График 4. Хүүхдэд ээлтэй байдлын бүлгийн индекс, 2020-2022



ЗГХА-ГБХЗХГ-ын даргын 2019 оны А/292 тушаалаар аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрууд Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журмын хэрэгжилтэд, 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/216 дугаартай Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын дагуу Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээ, үйл ажиллагаанд, 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/217 дугаартай Түр хамгаалах байрны үйлчилгээ үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийн дагуу Түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагаанд, 2020 оны А/243 дугаартай тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсийн сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалын дагуу Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журмын хэрэгжилтэд, 2023 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу Гэр бүлд зөвлөгөө өгөх төвд тавигдах нийтлэг шаардлага MNS 6417:2013 стандартын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээг тус тус хийсэн байна.

2019 онд хийгдсэн Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журмын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээгээр нэгдсэн дүгнэлт 16, сайжруулах шаардлагатай 16 зөвлөмж өгөгдсөн бөгөөд аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, зохион байгуулалтыг сайжруулах төлөвлөгөө боловсруулан байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж тайлагнах талаар чиглэлийг хүргүүлж ажилласан байна.

Хэнтий аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаанд 2019, 2021 онд хийгдсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг 7 үзүүлэлтээр харьцуулж үзэхэд байгууллагын үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ 2019 онд 63.8%, 2021 онд 55.3% буюу 7.5%-иар буурсан үзүүлэлт гарсан байна. Үүнээс байгууллагын үйл ажиллагаа, дотоод хяналтын үйл ажиллагаа гэх үзүүлэлтүүд 0.7-4.6%-иар буурсан нь ЗГХА-ГБХЗХГ-ын даргын 2019 онд өгсөн 16 дүгнэлт, 16 зөвлөмжийг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 11. ХГБХХГ-ын хяналтын үнэлгээ

№	Чиглэл	2019 он	2021 он
1	Байгууллагын үйл ажиллагаа	37.8%	37.2%
2	Дотоод хяналтын үйл ажиллагаа	56.4%	51.8%



Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журам, стандартын хэрэгжилтийн талаар 2019 онд 1, 2020 онд 3, 2023 онд 1 хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна. 2020 оноос хойш хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлийн хяналт-шинжилгээ үнэлгээ тогтмол хийгдээгүй байна.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос 2017 онд Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт зөвлөмжид орон нутгийн үйл ажиллагаа, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх боломжтой 65 зөвлөмж тусгагдсан байна.

Хүснэгт 12. Үүнээс аймгийн Хүүхэд гэр бүлийн, хөгжил хамгааллын газрын төлөвлөгөөнд туссан байдал:

№	Орон нутагт хэрэгжүүлэх боломжтой	Аймгийн ХГБХХГ-ын төлөвлөгөөнд агуулгын хувьд тусгагдсан тоо				
		2019	2020	2021	2022	2023
1	65	18	24	17	28	29

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн, хөгжил хамгааллын газар нь 2022 онд Азийн хөгжлийн банкнаас зарласан “Хүчирхэг ээжүүд” төслийн сонгон шалгаруулалтад оролцож 5000 долларын үнэ бүхий оёдлын тоног төхөөрөмж худалдан авч аймгийн Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж дууссан ээжүүдэд даван туулах, хөдөлмөр эрхлэх боломж олгох зорилготой тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн.


Төсөл хэрэгжүүлсэн Азийн хөгжлийн банкнаас төслийн үр дүнтэй танилцах, хэрэгжилтийг үнэлэх ажлын хэсэг 2023, 2024 онд ажилласан боловч төслийн үр дүнгийн талаар дүгнэлт зөвлөмж ирүүлээгүй байна.

Аймгийн ХГБХХГ-т 2019 онд ЗГХА-ГБХЗХГазраас Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журмын хэрэгжилтэд, 2021 онд ЗГХА-ГБХЗХГазраас байгууллагын үйл ажиллагаа, төсвийн зарцуулалтын үр дүнд, 2023 онд аймгийн ЗДТГ-ын ХШҮХэлтсээс хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдсэн байна.

Аймгийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж байгаагүй. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар тогтоолоор “2022 оныг Хүүхэд хөгжил, хамгааллын жил” болгон зарлахаар шийдвэрлэсэн. Энэ хүрээнд аймгийн Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн Ц.Чогсомжаваар 28 үйл ажиллагаа бүхий “Хүүхдийн хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Хүүхдийн хөгжил хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 90.3, аймгийн ИТХ-аас хангалттай гэж дүгнэжээ.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу “Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх”, 21.1-д “Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.



Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан жишиг хүүхэд хамгааллын бодлогыг баримтлан Хэнтийн аймгийн боловсролын салбарын байгууллагын 96.9%, эрүүл мэндийн салбарын байгууллагын 80%, соёл урлаг, спортын салбарын бүх байгууллага, Төр, хувийн хэвшлийн 77, нийт 188 байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулан баталсан байна.

Эрх бүхийн байгууллагын шийдвэрээр Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг батлаагүй байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлагдаагүй учраас дээрх 188 байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлж, нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлэх боломжгүй байна.

3.2. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний үр нөлөөг үнэлээгүй байна.

Байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөл 2019 онд 20, 2020 онд 45, 2021 онд 60, 2022 онд 189, 2023 онд 191 байгуулагдсан. Эцэг эхийн зөвлөлтэй 188 байгууллага нь хүүхэд хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж 2022, 2023 онуудад давхардсан тоогоор 95,5 мянган хүнийг хамруулан үйл ажиллагаа зохион байгуулсан. 2023 оны байдлаар Урьдчилан сэргийлэх ажилд хамрагдсан хүний тоо 22 хувиар өссөн. Эцэг эхийн зөвлөлтэй аж ахуйн нэгжийн тоо 22.2 хувиар нэмэгдсэн, 74 байгууллага хүүхдийн өрөөг тохижуулан ажиллаж өмнөх оноос 46.1 хувиар өссөн байна.

Төрийн 191 байгууллага эцэг эхийн зөвлөлтэй болсон нь сайн боловч 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа мэдээллийн санд бүртгэгдсэн давхардсан тоогоор 3355 хүүхдийн орчны нөхцөл байдал сайжирсан эсэх талаар хяналт-шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй байна.


Мөн 2019-2023 оны Хэнтийн аймгийн эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 2832 өрхийн 5917 хүүхдэд гэр эргэлт хийж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж гэр эргэлт хийсэн боловч эрсдэлийн мэдээллийн санд бүрэн бүртгээгүй байна.



Гэр бүлийн орчны эрсдэлт байдлыг бууруулсан талаар дүгнэлт, үнэлгээ гаргаагүй байна.

Боловсролын салбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6.1-д “Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана”, 6.2-д “Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талуудад заавал мэдээлэх” үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.



Боловсролын салбарын 64 байгууллагын хүүхэд хамгааллын талаарх статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах ажлыг аймгийн Боловсролын газар хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдлагууд хүүхэд хамгааллын чиглэлээр Зөвлөмж чиглэл хүргүүлж ажилласан байдлыг хүснэгтээр харуулбал.



Аймгийн Боловсролын газраас 2020 онд Хэрлэн сумын ерөнхий боловсролын сургуульд суралцдаг 6198 хүүхдийн судалгааг 26 асуулга маягтын дагуу үнэлэхэд 8.3% нь өндөр эрсдэлтэй гарсан байна.

Тухайн өндөр эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн судалгааг аймгийн Цагдаагийн газарт хүргүүлж аюулгүй байдлыг ханган хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн байна.



Эрүүл мэндийн салбар:

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7.1-д “Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ” гэх чиг үүргээ хэрэгжүүлсэн тухай мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй байна.

Тус хуулийн 7.2-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн, түүний гэр бүл, хувийн нууцад хамаарах мэдээллийг хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага, албан тушаалтан, хувь хүнд мэдээлэхийг хориглох бөгөөд задруулснаас үүдэн гарах үр дагаврыг өөрөө хариуцна” гэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, холбогдох мэдээллийн санд нэвтрэх эрх бүхий албан хаагчтай нууц хадгалах гэрээг байгуулан ажиллаж байна.

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоонд 2023 оны жилийн эцсийн байдлаар хамрагдвал зохих 0-17 насны 28812 хүүхэд байгаагаас 19729 хүүхэд буюу 68.5% нь хамрагдсан байна. Энэ нь аймгуудын дунджаас 0.7%-иар бага, улсын дунджаас 11.5%-иар илүү байна.

Хэнтий аймагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг 30 байгууллага байгаагаас 24 байгууллага хүүхэд хамгааллын бодлого боловсруулж мөрдөн ажиллаж байна. Эрүүл мэндийн газар нь эдгээр 24 байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Цахим орчин, хэвлэл мэдээлэл:

Цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх 2019-2023 оны хооронд Цахим орчин 2019 контентын уралдаан, 2022 онд хэвлэл мэдээллийн ажилтнуудад хүүхэд хамгааллын бодлого танилцуулах арга хэмжээ, 2023 онд Танихгүй найз 1-5 уралдаан, Призм продакшны бүтээсэн 4 контентуудыг иргэд олон нийтэд хүргэх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

2022 онд Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай цахим орчны аюулгүй байдлын талаар уулзалт зохион байгуулсан боловч мэдээллийн аюулгүй байдал, зохисгүй мэдээллийг түгээхгүй байх талаар гэрээ, санамж байгуулж ажиллаагүй байна.

Хэнтий аймагт тайзны үйл ажиллагаатай 22 соёлын төв, аймгийн орон нутаг судлах музей, ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулга, нийтийн номын сан зэрэг 25 байгууллагад 2022-2023 онд зохион байгуулах арга хэмжээний 11 удирдамж, холбогдох 11 албан бичгийг аймгийн Соёл урлагийн газраас хүргүүлэн ажилласан байна. Аймгийн хэмжээнд 2022-2023 онд зохион байгуулсан 11 арга хэмжээний удирдамжид хүүхдэд тохиолдож болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар 1 заалтыг тусгасан байна.


Гамшиг, онцгой байдал:

Хэнтий аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг 2023 оны 06 сарын 07-нд нэмж тодотгол хийсэн байна. Тус төлөвлөгөөний 2.4-д аймгийн онцгой комисс, гамшгаас хамгаалах албадын чиг үүргийг заасан бөгөөд Хүн ам, нийгмийн хамгааллын албаны чиг үүрэгт гамшиг ослын, үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд ээлтэй орон зайг бий болгох, хүүхэд хамгааллын асуудлаар бусад мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, сургуульд элсэхийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийн боловсролыг тасралтгүй явуулах ажлыг зохион байгуулах талаар тусгасан байна.

Гамшиг, гамшигын онцгой нөхцөл байдлын үед урьдчилан сэргийлэх зорилгоор боловсролын байгууллагуудад жил бүр сургалт зохион байгуулсан.



3.3. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнтэй хийгдэж байгааг бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна.



2019-2023 онуудад Хүүхдийн тусламжийн 108 утсанд нийт 421 дуудлага ирснийг 100 хувь шийдвэрлэсэн. Хэнтий аймаг хүүхдийн хөгжил хамгааллын жил болгон зарласан жилүүдэд 2022, 2023 онд хүүхдийн зөрчлийн дуудлагын тоо 52,7%-иар өссөн. Хүүхдийн эрхийн зөрчлийн дуудлага 908 ирснээс 421 дуудлага нь хүүхэд хамгааллын 108 утсанд бүртгэгдсэн байна. Дуудлагын мөрөөр шуурхай арга хэмжээ авч нийт бүртгэгдсэн 421 дуудлагад холбогдох арга хэмжээг авч, 100% хэрэгжүүлж ажилласан байна.

2019-2023 онд Хүүхдийн тусламжийн 108 утсанд бүртгэлгүй 487 дуудлага, мэдээлэл байна.



2019-2023 онд Бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон 53, хурдан мориноос унаж эрүүл мэндийн байгууллагаар эмчлүүлсэн 9, гэмт хэргийн сэжигтэн /холбогдогч/ 20, гэмт хэргийн хохирогч 78, хүүхдийн эрхийн зөрчилд холбогдсон 24, хүүхдийн тусламжийн 108



утсанд ирсэн 421 дуудлага, хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан 433, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан 249, хүүхэд харах үйлчилгээнд хамрагдаж буй 18, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ авсан 172 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн байна.

2019-2023 онд илэрсэн хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэргийн дуудлага мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд 80 орчим хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгдсэн байна. Гэмт хэрэг, зөрчилд өртсөн, холбогдсон хүүхдийн гэр бүлийн нөхцөл байдлыг судлахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгддэг, эцэг эхийн хараа хяналт сул, архины хамааралтай, амьжиргааны түвшин доогуур, хүүхдийн дэргэд архидан согтуурдаг зэрэг нь хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгаан болж байна.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



**МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

Залуучуудын гудамж-01, Баянмөнх баг, Хэрлэн сум,
Чингис хот, Хэнтий аймаг, 23000

Утас/Факс: (976) 7056 2151,

Цахим шуудан: infoazdtg@khentii.gov.mn


2024. 10. 28 № 9/Б26

танай _____-ны № _____-т

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж
буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан
бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Тайлангийн төсөлд өгөх саналгүй болно



Ц.ЧОГСОМЖАВ

Х. Агдунзүлс
Тогсоосъ!
2024. 10. 28



ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хэнтий аймаг хүүхдийн хөгжлийг дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2022, 2023 оныг Хүүхэд хөгжил хамгааллын зорилтот жил болгон төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, хүүхдэд ээлтэй байдлын индексийг тодорхойлсон байна.
2. Хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн хэдий ч аймгийн ХГБХХГ нь орон нутгийн хүүхэд хамгааллын бодлого боловсруулж батлуулаагүй, оролцогч талуудын ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага, мэдээлэл, зөрчлийн тоо буураагүй, статистик тоо мэдээ зөрүүтэй байна.
3. ХГБХХГ нь хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг ажилтны албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусгаагүй байна.
4. Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүд ажлын ачааллаас шалтгаалан тогтвортой ажиллахгүй байгаагаас хамтарсан багт ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байна.
5. Аймаг, сумын засаг дарга нь хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, нэг цэгийн үйлчилгээний зардал, түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлын төсвийг төлөвлөж, ИТХ-аар батлуулаагүй байна.
6. ХГБХХГ нь хүүхэд хамгааллын үйлчилгээний батлагдсан төсвийг зориулалт, арга хэмжээний дагуу зарцуулаагүй байна.
7. Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй, үр дүнг үнэлэх ажлыг хийгээгүй байна.



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Хэнтий аймгийн Засаг даргад:

- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.1-д заасны дагуу аймгийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах;
- Хүүхэд хамгааллын тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлын төсвийн төслийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төлөвлөж, ИТХ-аар батлуулж ажиллах

Аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргад

- Хүүхэд хамгааллын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мэргэшүүлэх сургалт зохион байгуулах.
- Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд шилжүүлэн зарцуулдаг зөрчлийг арилгаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж ажиллах

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргад

- Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлэх үүргээ хэрэгжүүлж мэдээллийн сан бүрдүүлж ажиллах.

Аймгийн Боловсролын газрын даргад

- Аймгийн боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын мэдээллийн санг бүрдүүлж, нэгтгэж байх.

Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Мэдээллийн нэгдсэн сантай болох, оролцогч байгууллага өөрсдийн эрхээр холбогдох мэдээллийг оруулж, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах тогтолцоог бүрдүүлэх.
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нэгдсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж батлуулах.
- Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын тухай хуулиар олгосон чиг үүргийг ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусгаж шинэчлэн боловсруулж батлуулж мөрдүүлэх.



ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 10 дугаар сарын 25

Дугаар А/36

Чингис хот

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан Г
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газарт, аймгийн Засаг дарга, аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитын тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэхийг аудитор (Т.Алтаншагай)-д даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

232410057



34



АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Аудитын нэр: Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн
Аудитын код: ХЭА-2024/20-22-ШТА-ГА

Байгууллагын нэр: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагддаг байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт А. Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, тогтолцоо оновчтой эсэх?						
1.1.	Хүүхэд хамгааллын бодлого, тогтолцоо нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үү? /Хангаж чаддаггүй байна уу?/	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1.		ЗӨВЛӨМЖ: Аймгийн хэмжээний хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэх, нийгмийн орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг хамаарах салбар байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгах		
1.1.1.	Хүүхэд хамгааллын талаар мөрдөж буй хууль тогтоомж, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан А/ТЗ дугаар тушаалаар "Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангагдаж байна уу?	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх заалт, Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын даргын 2022 оны А/ТЗ дугаар тушаалаар "Аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дүрэм"-ийн 3.3.1 дэх хэсгийн хүрээнд аймгийн хэмжээнд хүүхдийн хөгжил, хамгааллын нэгдсэн бодлогыг боловсруулж батлуулаагүй байна.				
1.1.2.	Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хүлээн авагчдын онцлог юу вэ?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй				
1.2.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэдийн санал, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан төлөвлөсөн үү?	Баталсан "Албан тушаалын тодорхойлолт" нь Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хуулиар хүлэсэн чиг үүрэгтэй хэрхэн уялдаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд албан тушаалын тодорхойлолтод тусгаагүй хуулиар хүлэсэн чиг үүрэг 15 байна. Эдгээрийн хэрэгжилтийг авч үзвэл тодорхой хэмжээнд хэрэгжсэн 5, хэрэгжилт тодорхой бүс 5, орон нутгийн хэмжээнд огт хэрэгжүүлээгүй 5 чиг үүрэгүүд байна.				
3	1.2.1. Хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага хуулиар хүлэсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадж байна уу?	Аймгийн хэмжээнд Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт хүчирхийлэлтэй холбоотой дуудлага мэдээлэл бүртгэх, уралдаанч хүүхдийн, эрсдэлт бүлгийн, хүүхэд харах үйлчилгээний бүртгэл хөтлөх, хохирогчид үзүүлсэн үйлчилгээ, хохирогчийн мэдээлэл, хамтарсан багуудаас кейс үзүүлсэн үйлчилгээ, төлөвлөгөө зэрэг мэдээллийг бүртгэн ажилладаг 4 төрлийн мэдээллийн сан байгаа хэдий ч 2 мэдээллийн санг одоогоор ашиглахгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Хүүхэд хамгааллын тухай хуулиар олгосон чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод бүрэн тусгах, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжилтийг үнэлж ажиллах		
4	1.2.2. Хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагааны мэдээлэл хаана нэгтгэгддэг вэ? Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн эсэх?	Мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн		ЗӨВЛӨМЖ: Мэдээллийн нэгдсэн сангай болох, оролцогч байгууллага өөрсдийн эрхээр холбогдох мэдээллийг оруулж, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах тогтолцоог бүрдүүлэх		
5	1.2.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай хүний нөөц тогтвортой, орон тоо хүрэлцээтэй, мэргэшсэн албан хаагчид ажилладаг эсэх?	Сумдын нийгмийн бодлогын түшмэлийн 11 нь буюу 61.1 хувь нь 1-4 жил ажилласан албан хаагчид байна.		ЗӨВЛӨМЖ: Албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх талаар судалгааг хийж дээд шатны байгууллагад уламжлах, мэргэшүүлэх сургалтыг жил, улирлаар төлөвлөн хэрэгжүүлэх		
Дэд зорилт Б. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх?						
2.1.	Хүүхэд хамгааллын санхүүжилт хүртээмжтэй байна уу?					
6	2.1.1. Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв, зардлыг судалгаанд үндэслэн үр дүнтэй тооцож төлөвлөсөн үү?	Нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны урсгал зардал, хамтарсан багийн үйл ажиллагааны зардал, хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөж хүргүүлээгүй байна.		Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний зардлын төсвийг жил бүр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардалд тусгайлан төлөвлөж Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хугацаанд ИТХ-д өргөн мэдүүлж батлуулж байх		
7	2.1.2. Хүүхэд хамгааллын төсөв хөрөнгө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж чадж байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй				



8	2.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад шаардлагатай нөөцийг оновчтой тодорхойлж, зардлыг хуваарилж чадаж байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
2.2. Хүүхэд хамгаалалд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл үр дүнтэй, хяналттай байна уу?					
8	2.2.1. Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан санхүүжилт, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан уу?	Хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний батлагдсан зардлаас 2022 онд 51.5 сая төгрөгийг, 2023 онд 148.2 сая төгрөгийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалд шилжүүлэн зарцуулсан байна.		ЗӨВЛӨМЖ: Хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх, хариу үйлчилгээний зардлыг урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардалд зарцуулах зөрчлийг арилгаж дахин давтахгүй байх	
9	2.2.2. Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалт нь ил тод тайлагнадаг эсэх?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
10	2.2.3. Хүүхэд хамгааллын талаар Олон улсын донор байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтын тогтолцоо бүрдсэн үү?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
11	2.2.4. Хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлж чадаж байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
12	2.2.5. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хүүхдийн хувь хүний нууц бүрэн хамгаалагддаг уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
13	2.2.6. Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв урьдчилсан сэргийлэх ажил болон хариу үйлчилгээнд оновчтой хуваарилганд төсөвлөгдсөн байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
Дэд зорилт В. Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх?					
3.1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжж буй үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо үр дүнтэй ажиллаж байна уу?					
14	3.1.1. Хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэгдсэн оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх салбарын онцлогт нийцсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалтай байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
15	3.1.2. Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн талаар тогтмол судалгаа шинжилгээ, хяналт-үнэлгээ хийгдэж байна уу?	Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журам, стандартын хэрэгжилтийн талаар 2019 онд 1, 2020 онд 3, 2023 онд 1 хяналт-шинжилгээ үнэлгээ хийгдсэн байна. 2020 оноос хойш хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлийн хяналт-шинжилгээ үнэлгээ тогтмол хийгдээгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж ажиллах	
16	3.1.3. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон Улсын байгууллагаас Засгийн газарт өгсөн зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж байна уу?	НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос Монгол Улсын 5-р тайланд өгсөн дүгнэлт зөвлөмжид тусгагдсан 65 зөвлөмжөөс аймгийн ХТБХХГ нь байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон, салбарын бодлогын баримт бичигт тусуулан хэрэгжүүлэх арга, хэмжээг авч ажиллах		ЗӨВЛӨМЖ: Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15.1.1-д заасны дагуу аймгийн хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах	
17	3.1.4. Хүүхэд хамгааллын чиглэлээр Олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн, үйл ажиллагаа хөтөлбөрийн үр дүнг тооцож, нэлтгэж дүгнэдэг үү?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй			
18	3.1.5. Бодлогын хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг бодитой хийж үнэн зөв тайлагнаж байна уу?	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу "Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх", 21.1-д "Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина" гэж заасны дагуу аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.		ЗӨВЛӨМЖ: Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж ажиллах	



19	3.1.6. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр дүнг үнэлж, нийгэмд гарч буй эерэг бодитой үнэлэх шалгуур аргачлал байна уу?	Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлагдаагүй учраас дээрх 188 байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлж, нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлэх боломжгүй байна.	ЗӨВЛӨМЖ: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-шинжилтээ үнэлгээ хийх нэгдсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж батлуулах.
20	3.1.7. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, үр дүнг үнэлж, нийгэмд гарч буй эерэг бодитой үнэлж нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлж байна уу?	Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлагдаагүй учраас дээрх 188 байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүнг үнэлж, нийгэмд гарч буй эерэг нөлөөг тооцож үнэлэх боломжгүй байна.	ЗӨВЛӨМЖ: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-шинжилтээ үнэлгээ хийх нэгдсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж батлуулах.
3.2	Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь үр нөлөөтэй байна уу?	Төрийн 191 байгууллага эцэг эхийн зөвлөлтэй болсон нь сайн боловч 2019-2023 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа мэдээллийн санд бүртгэгдсэн давхардсан тоогоор 3355 хүүхдийн орчны нөхцөл байдал сайжирсан эсэх талаар хяналт-шинжилтээ хийж дүгнэлт гаргаагүй байна.	ЗӨВЛӨМЖ: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-шинжилтээ үнэлгээ хийх нэгдсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж батлуулах.
21	3.2.1. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн орчинд нөлөөлж чадаж байна уу?	Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн орчинд нөлөөлж чадаж байна уу?	ЗӨВЛӨМЖ: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар нь Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-шинжилтээ үнэлгээ хийх нэгдсэн шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлал боловсруулж батлуулах.
22	3.2.2. Боловсролын салбар үйл ажиллагаандаа хүүхэд хамгааллын бодлогыг баримтлан ажиллаж байна уу?	Боловсролын салбарын 64 байгууллагын хүүхэд хамгааллын талаарх статистик мэдээллийг нэгтгэн боловсруулж дүн шинжилгээ хийх ажлыг аймгийн Боловсролын газар хэрэгжүүлж ажиллаагүй байна. 6.2-д "Сургалтын байгууллага, албан тушаалтан, багш, ажилтан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн, илрүүлсэн тохиолдолд Хүүхдийн эрхийн тухай хуулиар үүрэг хүлээсэн орлогчигч талуудад заавал мэдээлэх" үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллажгүй байна.	ЗӨВЛӨМЖ: Аймгийн боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын мэдээллийн санг бүрдүүлж, нэгтгэж байх.
23	3.2.3. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7.1-д "Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлнэ" гэх чиг үүргээ хэрэгжүүлсэн тухай мэдээллийн сан бүрдүүлж ажиллаагүй байна.	ЗӨВЛӨМЖ: Эрүүл мэндийн ажилтан ажил, үүргээ гүйцэтгэх явцаа эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар таамагласан, мэдсэн тохиолдолд хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтан, албан тушаалтан, эсхүл цагдаагийн байгууллагын алба хаагчид заавал мэдээлэх үүргээ хэрэгжүүлж мэдээллийн сан бүрдүүлж ажиллах.
24	3.2.4. Хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?	Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай цахим орчны аюулгүй байдлын талаар уулзалт зохион байгуулсан боловч мэдээллийн аюулгүй байдал, зохиустой мэдээллийг түгээхгүй байх талаар гэрээ, санамж байгуулж ажиллаагүй байна.	
25	3.2.5. Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй	
26	3.2.6. Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал хангагдаж байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй	
3.3	Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үр дүнтэй байх чаддаг байна уу?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй	
27	3.3.1. Монгол Улс Хүүхдийн эрхийн олон улсын конвенцод нэгдсэн үүргийг хангалттай хэрэгжүүлдэг үү?	Илэрсэн нөхцөл байдал байхгүй	



3.3.2. 108 угсанд ирсэн дуудлага, Хүүхдийн тусламжийн 108 угсанд ирсэн дуудлагын мөрөөр мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна. 2019-2023 онд Хүүхдийн тусламжийн 108 угсанд бүртгэлгүй 515 дуудлага, хэмжээ авдаг уу?	ЗӨВЛӨМЖ			
3.3.3. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ стандартд нийцсэн, түргэн шуурхай байна уу?				
3.3.4. Хүүхдийн эсрэг гэмт хэргийн суурь шалтгааныг судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч чадаж байна уу?				
3.3.5. Салбар бүрт хүүхэд хамгаалалтай холбоотой тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж эрсдэлийг бууруулж байна уу?				
28				
29				
30				
31				
НИЙТ ДҮН				

Бэлтгэсэн:

Аудитор:

Аудитор:


Ахлах аудитор:

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор:



Танилцсан:
Аймгийн Засаг дарга

Т.Алтаншагай

Х.Ермэгүл

Ц.Билэгсайхан

Д.Оюунтуяа

Ж.Ганбаатар

Огноо 2023.08.23

Огноо 2023.08.23

Огноо 2023.08.23

Огноо 2023.08.23

Огноо 2023.08.23

Ц.Чогсомжав

Н.Зоригтбаатар

Х.Уртнасан

С.Мөнхцэцэг

Б.Энхболор

Огноо 2023.10.25

Огноо 2023.10.25

Огноо 2023.10.25

Огноо 2023.10.25

Огноо 2023.10.25

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn